



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/21

Улаанбаатар хот


Гадаад сурталчилгааны ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 115 дугаар тогтоол, “Гадаад сурталчилгааны ажил зохион байгуулах тухай” нийслэлийн Засаг даргын 2023 оны А/420 дугаар захирамж, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүгд найрамдах Солонгос улсын Сөүл хотод 2023 оны 05 дугаар сарын 04-07-ны өдрүүдэд зохион байгуулагдах “Сөүлийн олон улсын аялал жуулчлалын экспо” арга хэмжээ, Улаанбаатар хотод 2023 оны 05 дугаар сарын 06-09-ны өдрүүдэд зохион байгуулагдах БНСУ-ын тур операторуудын уулзалт арга хэмжээнд Улаанбаатар хотыг сурталчилж ажиллах, жуулчдыг хэрэгцээт мэдээ мэдээллээр хангах ажлыг зохион байгуулсугай.

2. Арга хэмжээг зохион байгуулах төсвийг хавсралтаар баталж шаардагдах 44,399,414 /дөчин дөрвөн сая гурван зуун ерэн есөн мянга дөрвөн зуун арван дөрөв/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Уянга/-д зөвшөөрсүгэй.

3. Арга хэмжээ зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөг батлуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулахыг Ажлын хэсэг /В.Батчимэг/-т даалгасугай.

ДАРГА  Д.БАТСҮХ



1159599131

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2023 оны 05 сарын 02 өдрийн
А.А. дугаар тушаалын хавсралт

АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ТӨСӨВ

2023 оны 05 дугаар сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

1. "Сөүлийн олон улсын аялал жуулчлалын экспо" арга хэмжээ				
№	Зардлын төрөл	Тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Үзэсгэлэнгийн талбайн түрээс	27 м ²	3 600 ам.доллар	3 600 ам.доллар
2	Талбайн тохижилтын зардал	Багц	3 420 ам.доллар	3 420 ам.доллар
3	Арга хэмжээний урлагийн тоглолтын зардал	Багц	5 000 000 төгрөг	5 000 000 төгрөг
Нийт: 7020 ам.доллар, 5 000 000 (таван сая) төгрөг Гадаад валютыг тухайн өдрийн Монгол банкны ханшаар тооцно.				
2. БНСУ-ын тур операторуудын уулзалт зохион байгуулах тухай				
5	Гадаадын зочид, төлөөлөгчдийг байршуулах зочид буудлын зардал	100 хүн	115 000 төгрөг	11 500 000 төгрөг
6	Гадаадын зочид, төлөөлөгчдийг байршуулах амралтын газрын зардал	100 хүн	35 000 төгрөг	3 500 000 төгрөг
НИЙТ				15 000 000 төгрөг
Нийт дүн				20 000 000 төгрөг, 7020 ам.доллар
Гадаад валютыг тухайн өдрийн Монгол банкны ханшаар тооцно.				

--o0o--